



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/162

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтооцуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Батдайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 73 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Жамбалын Гансүх /ИД91061011/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар, хаягийг Батмонгол 3 дугаар гудамжны 308 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Магсаржав багийн 1 дүгээр гудамжны 32 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Бямбаагийн Бат-Эрдэнэ /ПД91070339/-ийн эзэмшлийн 1081 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Мөнхсүлдийн Сувдаа /ПН71071103/-д газрын хэмжээг хаягийн мэдээллийн сангийн зургийн дагуу 1069 метр квадрат, хаягийг Баянгол 1 дүгээр гудамжны 106 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Буянт багийн эко 1 дүгээр гудамжны 17 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Цогбадрахын Оюунаа /ПЮ61052029/-ийн эзэмшлийн 806 метр квадрат газрыг өвлөх эрхийн гэрчилгээний дагуу Хүрлээгийн Эрдэнэзяа /ПЮ88011012/-д газрын хэмжээг хаягийн мэдээллийн сангийн зургийн дагуу 814 метр квадрат, хаягийг Жаргалант хайрхан 2 дугаар гудамжны 231 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 7 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Жаргалан багийн Залуус 3 дугаар гудамжны 301 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай Баядбаатарын Нацаг /ПЮ44020313/-ийн эзэмшлийн 664 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Мягмардоржийн Буянбилэг /ПЮ000271145/-д 4 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

5. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

6. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ